



## АХИЦ ДЭВШЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: СИТИ ИХ СУРГУУЛЬ, УРЛАГИЙН СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: “ЖҮЖИГЛЭХ УРЛАГ” БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР  
Индекс: D021505

Шинжээч: Шинжээч: Б.Отгонтөгс – ХААИС, Сургалтын хөтөлбөрийн эрхлэгч, Ph.D

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар .....	3
Хөтөлбөрийн танилцуулга .....	7
Зөвлөмжийн дагуу:	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт .....	8
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа .....	9
Шалгуур 3. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц .....	10
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт .....	11
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ .....	12
Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн .....	13
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт .....	15
Шинжээчийн дүгнэлт.....	17
Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал .....	18
Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

## Товчилсон үгийн тайлбар

БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөл
ЖУ	Жүжиглэх урлаг
ҮДСБ	Үр Дүнд Суурилсан Боловсрол
ӨҮТ	Өөрийн Үнэлгээний Тайлан
СИС	Сити Их Сургууль
СБЗГ	Сургалтын бодлого зохицуулалтын газар
PEOs	Program Educational Objectives Хөтөлбөрийн боловсролын зорилтууд
PLOs	Program Learning Outcomes- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд
CLOs	Course Learning Outcomes Хичээлийн суралцахуйн үр дүнгүүд
STEEP	Social, Technological, Economic, Environmental, Political analysis -Нийгэм, Технологи, Эдийн засаг, Хүрээлэн буй орчин, Улс төрийн үр нөлөөг тооцох чиг хандлагын шинжилгээний арга.

## 1. Үйл явц, төлөвлөлт

<b>Сургууль</b>	СИС-ийн Урлагийн сургууль	
<b>Хөтөлбөр</b>	“Жүжиглэх урлаг” бакалаврын хөтөлбөр	
<b>Индекс</b>	D021505	
<b>Үнэлгээний баг</b>	Шинжээч	Б.Отгонтөгс – ХААИС, Сургалтын хөтөлбөрийн эрхлэгч, Ph.D
<b>Төлөвлөгөө</b>	<b>Өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	2022.12.16	Жүжиглэх урлаг хөтөлбөрийн нотлох баримттай сургууль дээр нь очиж танилцсан.
	2022.12.16	Сургуулийн өөрийн үнэлгээний багт шинжээчийн үнэлгээний тайланг урьдчилсан байдлаар танилцуулсан.
<b>Үндэслэл</b>	Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын 2.2.2, 5.1.2 дахь заалт; Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирлын 2022 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/190 тоот тушаал	

## 2. Жүжиглэх урлаг хөтөлбөрт ДБМИК-оос өгсөн зөвлөмж

Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 07 дугаар сарын 02-ны 06 дугаар тогтоолын хавсралтаар дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

<b>Зөвлөмж:</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн төлөвлөлт хийх, ирээдүйн эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо хөтөлбөрийн оролцогч талуудын судалгааг тогтмолжуулж, чухал санал зөвлөмжийг хөтөлбөрийн сайжруулалтад тодорхой тусгаж ямар өөрчлөлт сайжруулалт хийгдсэнийг нэгтгэн дүгнэсэн тайлан гаргаж, тасралтгүй сайжруулах тогтолцоог бий болгох</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн(PLOs)-г үйлээр илэрхийлэн зөв тодорхойлох;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн төгсөгчийн загвар, Хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs), хичээлийн суралцахуйн үр дүнгүүд(CLOs) хоорондын уялдаа холбоог тодорхой гаргаж багш, оюутнуудад ойлгуулах, сургалтын эдгээр үр дүнг оюутанд эзэмшүүлэхэд чиглүүлэх</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэх стратеги төлөвлөлтийг хийж, түүнийг үнэлэх арга, хэмжих нэгжийг тодорхой болгон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн суралцахуйн хүрэх үр дүнд хүрч чадаж байгаа талаарх судалгаа, хөндлөнгийн үнэлгээ дутмаг байгааг анхаарч цаашид сайжруулж ажиллах.</li> </ul>
Шалгуур 2.	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын хөтөлбөрийн сайжруулалтыг үндсэн баримт тусгаж, тасралтгүй сайжруулалтыг хийж хэвших;</li> </ul>

<p>Сургалтын үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Жүжиглэх урлаг хөтөлбөрийн хувьд сурган заах арга, суралцахуйн үнэлгээ нь харилцан уялдаатай байх талд анхаарч хичээлийн түвшнээс хөтөлбөрийн түвшинд хүртэл төлөвлөлт, хэрэгжүүлэлт, сайжруулалтыг тасралтгүй хийдэг тогтолцоог бүрдүүлэх.</li> <li>• Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмж бүхий гарын авлага боловсруулж, хөтөлбөрийн багш нарт хүртээл болгох.</li> <li>• Багш нарыг сурган, заах арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжүүлэх багшийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг гаргаж, хэрэгжүүлэх.</li> <li>• Цаашид хичээлийн суралцахуйн үр дүн бүрийг багш хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүй боловсруулж, гарын авлага гаргах, түүнийг багш нарт зааж эзэмшүүлэх;</li> </ul>
<p>Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцагчийн хувь хүний ур чадварыг ялангуяа жүжигчний онолын мэдлэг, судалгааны ажил бичих ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай.</li> <li>• Оюутнуудын бие даасан сургуулилтын цаг, нөөц бололцоо гаргах тал дээр онцгой анхаарах шаардлагатай.</li> <li>• Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сурах бичгийг орчуулан сургалтад хэрэглэх абан ёсны зөвшөөрөл авахад сургуулийн зүгээс анхаарч ажиллах;</li> <li>• Мэргэжлийн багш нар гадаад хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийг Монгол хэлрүү орчуулж, сургалтад ашиглах талд анхаарах;</li> <li>• Тэнхмийн багш нар гадаад хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийг Монгол хэлрүү орчуулж, сургалтад ашиглах талд анхаарах;</li> </ul>
<p>Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журмын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг тогтмол хийх зэргийг зөвлөмжилж байна.</li> <li>• Санамж бичгийн түвшинд байгаа хамтын ажиллагааны баримт бичгүүдээ гэрээний түвшинд хөгжүүлж баталгаажуулах</li> <li>• Хөтөлбөрийн төсвийн зарцуулалтын тайланг ил тод мэдээлэх механизмыг бүрдүүлэх</li> </ul>
<p>Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг судалж, элсэгчдэд тавих тусгай шаардлага, шалгуурт тусгаж ажиллахыг зөвлөж байна.</li> <li>• Шилжилт хөдөлгөөний шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийхийг зөвлөмжилж байна.</li> </ul>
<p>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн бодлогыг СИС-ийн мастер төлөвлөгөөндөө дэлгэрэнгүй тусган, уг бодлогын хүрээнд дадлага, туршлагатай ахмад багш нарт залуу багш нарыг дагалдуулах замаар багш нарын залгамж халааг бэлтгэх шаардлагатай.</li> <li>• Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг тодорхой болгох.</li> <li>• Багшийн ажиллаж буй албан тушаалын зэрэглэлийн жилийн ачааллыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэлгүй ачаалах бодлого баримтлан ажиллах.</li> <li>• Багш нарыг шагнаж урамшуулах системийг боловсронгуй болгох.</li> <li>• Багш нарын хувийн хэрэг, төлөвлөгөө, тайлангийн чанарыг сайжруулах шаардлагатай.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Багшийн урамшууллын бодлогыг боловсруулж, санхүүгийн төсөвт тусгах.</li> <li>• Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын сэдвийг шинэчлэх, цар хүрээг тэлэх</li> <li>• Багш нарын бүтээлийг олон улсын хөндлөнгийн хянан магадлагаа бүхий сэтгүүлүүдэд хэвлүүлэх, гадаад хэлэнд хөрвүүлэхэд анхаарах</li> <li>• Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоог нэмэгдүүлэх</li> <li>• Ажлын үнэлгээтэй уялдуулан цалин хөлсийг нэмэгдүүлэхэд анхаарах.</li> <li>• Аттестатчилалд орох асуудал нь багш нарын сайн дурын үндсэн дээр хийгддэг байдлыг албан ёсны болгох шаардлагатай.</li> </ul>
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын чанарын баталгаажилтын журмын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийхийг зөвлөмжилж байна.</li> <li>• Сэтгэл ханамжийн судалгаа гүйцэтгэх цогц баримт бичиг боловсруулан мөрдөхийг зөвлөмжилж байна.</li> <li>• Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үндэсний болон олон улсын шалгуур шаардлагад нийцүүлэн ахиц дэвшлээ тогтмол үнэлж хэвших</li> </ul>

### Нэг. “Жүжиглэх урлаг” бакалаврын хөтөлбөрийн танилцуулга

Сити их сургууль нь анх 1998 онд “Монголжингоо” нэртэй байгуулагдаж байсан Боловсролын Магадлан итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлөөр 2005, 2010 онд байгууллагын магадлан итгэмжлэлд хамрагдаж анхан шатны болон ахисан түвшинд магадлан итгэмжлэгдсэн, 2012 онд БСШУЯ-нд аттестатчилагдсан 20 гаруй жилийн түүхтэй сургууль юм.

Тус сургууль нь “Жүжиглэх урлаг” хөтөлбөрөөр 2006 онд анхны элсэлтээ авч, үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч удирдлага нь 2010 онд Урлаг гоо сайхны факультет, 2016 онд Урлагийн сургууль болон өргөжсөн.

Урлагийн сургуулийн “Жүжиглэх урлаг” тэнхим нь “Жүжиглэх урлаг” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ба 14 жилийн хугацаанд 10 удаагийн төгсөлт хийн, 201 жүжигчин мэргэжилтэнг бэлтгэн гаргаж Монголын тайз, дэлгэцийн урлагт өөрийн хувь нэмрээ оруулж, нийгмийн хөгжил, эрэлт хэрэгцээнд тулгуурлан үр дүнд суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлалаар хөгжин сайжирч хэрэгжиж буй хөтөлбөр юм.

## ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

#### Зөвлөмж, шаардлага

1. Хөтөлбөрийн төлөвлөлт хийх, ирээдүйн эрэлт хэрэгцээг тодорхойлохдоо хөтөлбөрийн оролцогч талуудын судалгааг тогтмолжуулж, чухал санал зөвлөмжийг хөтөлбөрийн сайжруулалтад тодорхой тусгаж ямар өөрчлөлт сайжруулалт хийгдсэнийг нэгтгэн дүгнэсэн тайлан гаргаж, тасралтгүй сайжруулах тогтолцоог бий болгох
2. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн(PLOs)-г үйлээр илэрхийлэн зөв тодорхойлох;
3. Хөтөлбөрийн төгсөгчийн загвар, Хөтөлбөрийн боловсролын зорилтууд(PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs), хичээлийн суралцахуйн үр дүнгүүд(CLOs) хоорондын уялдаа холбоог тодорхой гаргаж багш, оюутнуудад ойлгуулах, сургалтын эдгээр үр дүнг оюутанд эзэмшүүлэхэд чиглүүлэх
4. Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэх стратеги төлөвлөлтийг хийж, түүнийг үнэлэх арга, хэмжих нэгжийг тодорхой болгон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;
5. Хөтөлбөрийн суралцахуйн хүрэх үр дүнд хүрч чадаж байгаа талаарх судалгаа, хөндлөнгийн үнэлгээ дутмаг байгааг анхаарч цаашид сайжруулж ажиллах.
6. Сургалтын хөтөлбөрийн сайжруулалтыг үндсэн баримт тусгаж, тасралтгүй сайжруулалтыг хийж хэвших;

#### Баримт нотолгоо, үнэлгээ:

Дээрх зөвлөмж, шаардлагын хүрээнд дараах шинэчлэлт, сайжруулалтыг хийсэн нь нотлох баримтаар баталгаажиг байна. Үүнд:

- Хөтөлбөрийн төлөвлөлтийг 2026 он хүртэл хийж, хөгжүүлэлтийг стратеги төлөвлөгөөнд үе шаттай хөгжүүлэхээр тусгаснаас гадна хөтөлбөрийн оролцогч талуудын судалгаа авч, анализ хийн хөтөлбөрт сайжруулалт хийж “Жүжиглэх урлаг” хөтөлбөр, 2023 -д тусгасан байна.
- СИС нь 2022 онд бүтцийн өөрчлөлт хийж, сургалт эрхэлсэн албатай болж, тус албанаас үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн стандарт боловсруулах ажлуудыг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байгаа ба энэ ажлын хүрээндээ Хөтөлбөрийн төгсөгчийн загвар, Хөтөлбөрийн боловсролын зорилтууд (PEOs), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд(PLOs), хичээлийн суралцахуйн үр дүнгүүд(CLOs)-ийг шинэчлэн боловсруулж, хоорондын уялдаа холбоог матрицаар гаргаж, үйлээр илэрхийлэн тодорхойлсон байна.
- БШУЯ-ны Сайдын А/174 тушаалын агуулгын дагуу “Жүжиглэх урлаг” хөтөлбөрийг 2023 онд шинэчлэн боловсруулсан байна.
- СИС-ийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, 2021
- СИС-ийн Урлагийн сургуулийн Жүжиглэх урлагийн тэнхмийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа

**Шалгуурын хангасан байдал:** Бүрэн хангасан

## ШАЛГУУР ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Зөвлөмж:

1. Сургалтын хөтөлбөрийн сайжруулалтыг үндсэн баримтад тусгаж, тасралтгүй сайжруулалтыг хийж хэвших;
2. Жүжиглэх урлаг хөтөлбөрийн хувьд сурган заах арга, суралцахуйн үнэлгээ нь харилцан уялдаатай байх талд анхаарч хичээлийн түвшнээс хөтөлбөрийн түвшинд хүртэл төлөвлөлт, хэрэгжүүлэлт, сайжруулалтыг тасралтгүй хийдэг тогтолцоог бүрдүүлэх.
3. Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмж бүхий гарын авлага боловсруулж, хөтөлбөрийн багш нарт хүртээл болгох.
4. Багш нарыг сурган, заах арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжүүлэх багшийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг гаргаж, хэрэгжүүлэх.

### Баримт нотолгоо, үнэлгээ:

Дээрх шаардлагын хүрээнд дараах шинэчлэлт, сайжруулалтыг хийсэн нь нотлох баримтаар баталгаажиг байна. Үүнд:

- “Жүжиглэх урлаг” хөтөлбөрийг 2022 онд Монгол Улсын Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2014 оны 04 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар баталсан “Бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын дагуу шинэчлэн боловсруулж батлуулсан байна.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо Блумын таксономын үйлийн системчилсэн ангилалтай уялдуулан тогтоосон.
- Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг (CLO)-г хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх аргазүйн зөвлөмж бүхий гарын авлага боловсруулсан.
- Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг “Бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын дагуу шинэчлэн боловсруулж, хичээл хоорондын уялдаа холбооны зураглалыг гаргаж улирал бүр үзэх хичээлүүд ба хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийн хамаарлыг тодорхойлсон байна.
- “Либерал арт” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Ингэснээр оюутан 2-р курсээсээ бусад мэргэжлийн хичээлүүдээс сонгон суралцах боломж олгосон байна.
- СИС-ын “Багшийн хөгжлийн хөтөлбөр (2020-2025)
- Багш нарын мэдлэг боловсролыг үе шаттайгаар дээшлүүлэх зорилго бүхий “Багшийн хөгжлийн хөтөлбөр (2020-2025)-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2022

**Шалгуурын хангасан байдал:** Бүрэн хангасан



## ШАЛГУУР ГУРАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

### Зөвлөмж, шаардлага:

1. Суралцагчийн хувь хүний ур чадварыг ялангуяа жүжигчний онолын мэдлэг, судалгааны ажил бичих ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай.
2. Оюутнуудын бие даасан сургуулилтын цаг, нөөц бололцоо гаргах тал дээр онцгой анхаарах шаардлагатай.
3. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сурах бичгийг орчуулан сургалтад хэрэглэх абан ёсны зөвшөөрөл авахад сургуулийн зүгээс анхаарч ажиллах;
4. Мэргэжлийн багш нар гадаад хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийг Монгол хэлрүү орчуулж, сургалтад ашиглах талд анхаарах;
5. Тэнхмийн багш нар гадаад хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийг Монгол хэлрүү орчуулж, сургалтад ашиглах талд анхаарах;

### Баримт нотолгоо, үнэлгээ:

Дээрх зөвлөмж, шаардлагын дагуу дараах сайжруулалтыг хийж ажилласан нь дараах баримтуудаар нотлогдож байна. Үүнд:

- Суралцагчийн хувь хүний ур чадвар, судалгааны ажил бичих ур чадварыг хөгжүүлэх зорилгоор оюутнаар дипломын бичвэр (уран бүтээлээр хамгаалдаг) бичүүлж байна. Энэ нь оюутанд онолын мэдлэгээс гадна судалгааны ажлын чадвар эзэмшүүлж байна.
- СИС-ын оюутны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилго бүхий Эрдэм шинжилгээний хурлыг 2022 онд 2 удаа зохион байгуулж, жүжиглэх урлаг тэнхимээс 8 оюутан илтгэл тавьж амжилттай оролцсон.
- “Сити номын сан” цуврал үйл ажиллагааг эхлүүлсэн.
- Жилд 2 удаа мастер сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- 2022 онд Н.Пүрэвдагва, С.Туяа нарын орчуулсан Берьтолд Брехт “Театр, шүлэг найраг, нийтлэл, ярилцлага хэлсэн үг” номыг сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн дэмжүүлж санхүүжүүлэн хэвлүүлж сургалтад ашиглаж байна.
- Багш нар “СИТИ Science” сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэх, сурах бичиг бичих зэрэгт багшийн ажлыг үнэлэх А, Б, В цагийн гүйцэтгэл дээр нэмэлт кредит цагаар тооцон урамшуулж байна.
- Багш Х.Чойдогжамц, О.Пүрэвдулам нарын “Театрын урлагийн нэр томъёоны тайлбар толь” бүтээх ажлыг сургуулийн эрдмийн зөвлөлөөр дэмжсэн.
- Тайзны ярианы багш нар “Голос” номыг орчуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Багш Х.Чойдогжамц нь “Утга зохиолын судлал шинжлэл” редакцийн завлелд ажилладаг ба Өрнийн канон, Уран бүтээл шинжлэхүйн үндэс номуудыг редакторлож, сургалтад гарын авлагаар ашиглаж байна.
- Багш Т.Төмөр-Очир нь А.Метта “Там ба диваажингийн хооронд кино буй” хэмээх мэргэжлийн сурах бичгийг орчуулж, эрдмийн зөвлөлөөр дэмжүүлэн сургалтад ашиглаж байна.
- Багш А.Баярцэцэг, И.Чаббак нар “Дүр бүтээх увидас” гарын авлагыг орчуулан сургалтад ашиглаж байна.
- Монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор СИС нь АНУ дахь Монгол соёлын төвтэй хамтран ажиллаж сургуулиас бүрэн санхүүжүүлэн 2022 онд 1

багшид 20 сая төгрөгийн санхүүжилт үзүүлж АНУ явуулсан ба 2023 онд 3 багш явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- СИС-ын А байрны өргөтгөлийн засварын ажлыг гүйцэтгэж байна.

### **Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **Зөвлөмж, шаардлага:**

1. Хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журмын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг тогтмол хийх зэргийг зөвлөмжилж байна.
2. Санамж бичгийн түвшинд байгаа хамтын ажиллагааны баримт бичгүүдээ гэрээний түвшинд хөгжүүлж баталгаажуулах
3. Хөтөлбөрийн төсвийн зарцуулалтын тайланг ил тод мэдээлэх механизмыг бүрдүүлэх

### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Дээрх зөвлөмж, шаардлагын дагуу дараах сайжруулалтыг хийж ажилласан нь дараах баримтуудаар нотлогдож байна. Үүнд:

- СИС-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 22-нй А/78 дугаар тушаалаар “Чанарын дотоод баталгаажуулалтын алба”-ыг шинээр байгуулсан ба энэхүү албанаас Чанарын дотоод баталгаажуулалтын журмыг боловсруулсан. Тус журмын 2.6, 4.1-т заасны дагуу хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журмын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийж байна.
- Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажиллах санамж бичгийг гэрээжүүлж, контентэд оюутан оролцуулах зорилгоор эхний ээлжинд 3 сая төгрөгний санхүүжилт хийгдсэн байна.
- СИС нь Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах санамж бичиг байгуулсан байна.
- Европын холбооны “Erasmus mundus” -ын “Цахим шилжилт” төсөл амжилттай хэрэгжиж энэ хүрээнд 6 сар хүртлэх оюутан солилцооны хөтөлбөр, мөн Франц улсын ??? сургуультай судлаач солилцооны хөтөлбөр тус тус хэрэгжиж байна.
- Хөтөлбөрийн төсвийн зарцуулалтын тайланг ил тод хэлэлцүүлж байна. Тухайлбал СИС нь шинээр Мэдээлэл технологийн газартай болсон ба эндээс сургалт судалгааны бүх үйл ажиллагааг цахим байдлаар нийтэд түгээж байна.

### **Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан**

## **ШАЛГУУР ТАВ. СУРАЛЦАГДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ**

### **Зөвлөмж, шаардлага:**

1. Ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг судалж, элсэгчдэд тавих тусгай шаардлага, шалгуурт тусгаж ажиллахыг зөвлөж байна.
2. Шилжилт хөдөлгөөний шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийхийг зөвлөмжилж байна.

### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Дээрх зөвлөмж, шаардлагын дагуу дараах сайжруулалтыг хийж ажилласан нь дараах баримтуудаар нотлогдож байна. Үүнд:

- СИС-ийн элсэлтийн үйл ажиллагаанд Боловсролын тухай хуулийн 33-р зүйлийн 33.1 дэх хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 11-р зүйлийн 11.3 дахь хэсэг, 12-р зүйлийн 12.1.6 дахь дахь заалт, БШУС-ын 2013 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам, БШУС-ын 2021 оны А/187 дүгээр тушаалаар батлагдсан “Босго оноо тогтоох тухай”, СИС-ийн дүрмийн 6.3 дахь хэсэг, СИС-ийн “Оюутан элсүүлэх журам”-ын 5.1 хэсгийг тус тус баримтлан ажиллаж байна.
- Тус хөтөлбөрөөр жил бүрийн элсэгчдээс судалгаа авдаг бөгөөд судалгааны үр дүнгээс дараа жилийн элсэлтийн журам, үйл ажиллагааны сайжруулалтын төлөвлөлтийг тодорхойлдог. Тус ахиц дэвшлийн тайлант хугацаанд намрын улиралд судалгаа авсан ба хаврын улиралд дахин авсны дараа зарим саналыг тусгах болно.
- Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар ур чадварын шалгалт авдаг. Үүнд:ярилцлага, этюд, дуулалт, шүлэг, сонсгол, бүжиг, монологи зэрэг шалгуур багтдаг.
- Шилжилт хөдөлгөөний шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийсэн байна.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа

### **Шалгуурын хангасан байдал: Бүрэн хангасан**

### **ШАЛГУУР ЗУРГАА: БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **Зөвлөмж, шаардлага:**

3. Хүний нөөцийн бодлогыг СИС-ийн мастер төлөвлөгөөндөө дэлгэрэнгүй тусган, уг бодлогын хүрээнд дадлага, туршлагатай ахмад багш нарт залуу багш нарыг дагалдуулах замаар багш нарын залгамж халааг бэлтгэх шаардлагатай.
4. Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг тодорхой болгох.
5. Багшийн ажиллаж буй албан тушаалын зэрэглэлийн жилийн ачааллыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэлгүй ачаалах бодлого баримтлан ажиллах.
6. Багш нарыг шагнаж урамшуулах системийг боловсронгуй болгох.
7. Багш нарын хувийн хэрэг, төлөвлөгөө, тайлангийн чанарыг сайжруулах шаардлагатай.
8. Багшийн урамшууллын бодлогыг боловсруулж, санхүүгийн төсөвт тусгах.
9. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын сэдвийг шинэчлэх, цар хүрээг тэлэх

10. Багш нарын бүтээлийг олон улсын хөндлөнгийн хянан магадлагаа бүхий сэтгүүлүүдэд хэвлүүлэх, гадаад хэлэнд хөрвүүлэхэд анхаарах
11. Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоог нэмэгдүүлэх
12. Ажлын үнэлгээтэй уялдуулан цалин хөлсийг нэмэгдүүлэхэд анхаарах.
13. Аттестатчилалд орох асуудал нь багш нарын сайн дурын үндсэн дээр хийгддэг байдлыг албан ёсны болгох шаардлагатай.

### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Дээрх зөвлөмж, шаардалгын дагуу дараах сайжруулалтыг хийж ажилласан нь дараах баримтуудаар нотлогдож байна. Үүнд:

- СИС нь дадлага, туршлагатай ахмад багш нарт залуу багш нарыг дагалдуулах замаар залгамж халааг бэлтгэх тэдний мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор МУГЖ И.Одончимэг, С.Өлзийхүү, Т.Төмөр-Очир нарыг багшаар ажиллууж байна.
- СИС нь 2022 онд “СИС-ийн багшийн ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулсан ба уг журмын 6.1-д Багшийн албан тушаалын зэрэглэл, түүнд тавигдах шаардлагыг тодорхой заасан байна. Мөн “СИС-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны А/39 тоот тушаалаар батлагдсан “СИС-ийн багшийн ажлын хэмжээ кредит тооцох журам”-ыг шинэчлэн боловсруулсан ба энд Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажил гэсэн 3 төрөлд ангилан тодорхойлсон байна.
- Мөн “СИС-ийн багшийн шагнал урамшуулал” журмыг шинэчлэн боловсруулж уг журмын 2-р хэсэгт багшийг хэрхэн урамшуулах талаар тодорхой тусгасан байна.
- Багш нарын хувийн хэрэг, төлөвлөгөө, тайлангийн чанарыг сайжруулах зорилгоор СИС-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны А/62 тоот тушаалаар батлагдсан “СИС-ийн багшийн тайлан бичих заавар”-ыг баталж энд багшийн ажлын тайлан хэрхэн бичих зааварыг тодорхой тусгасан байна.
- СИС-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 05 сарын 17-ны А/39 тоот тушаалаар “СИС-ийн багш нарыг аттестатчилах, тэнхим /профессорын баг/-ийн рейтинг тогтоох журам”-ыг шинэчлэн боловсруулсан ба тус журмын 2.1, 2.4, 2.5-д багшийн ажлын үнэлэх тухай тусгасанаас гадна 2022 онд шинэчлэн боловсруулсан “СИС-ийн багшийн ажиллах журам”-ын 13-д Багшийн ажлыг үнэлж, дүгнэх тухай гэсэн тодорхой заалт оруулсан байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын сэдвийг шинэчлэх, цар хүрээг тэлэх, багш нарын судалгаа шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 01 сард А/10 тоот тушаалаар “СИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн журам”-ыг шинээр боловсруулсан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд багш нарын эрдэм шинжилгээний болон уран бүтээлийн бүтээмж өмнөх оноос нэмэгдсэн байна.
- Аттестатчилалд орох асуудал нь багш нарын сайн дурын үндсэн дээр хийгддэг байсныг албан ёсны болгож СИС-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 05 сарын 17-ны А/39 тоот тушаалаар “СИС-ийн багш нарыг аттестатчилах, тэнхим

/профессорын баг/-ийн рейтинг тогтоох журам"-ыг шинэчлэн боловсруулж нийт сургуулийн хэмжээнд аттестатчилалыг зохион байгуулсан ба үүний үр дүнд 3 багшийн цалинг нэмэгдүүлсэн байна.

- СИС-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 08 сарын 31-ны А/59 тоот “СИС-ийн хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай тушаал
- СИС-ийн багшийн эрдэм шинжилгээний бүтээлийг урамшуулах журам

**Шалгуурын хангасан байдал:** Бүрэн хангасан

## **ШАЛГУУР ДОЛОО. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖУУЛАЛТ**

### **Зөвлөмж, шаардлага:**

- Сургалтын чанарын баталгаажилтын журмын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийхийг зөвлөмжилж байна.
- Сэтгэл ханамжийн судалгаа гүйцэтгэх цогц баримт бичиг боловсруулан мөрдөхийг зөвлөмжилж байна.
- Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үндэсний болон олон улсын шалгуур шаардлагад нийцүүлэн ахиц дэвшлээ тогтмол үнэлж хэвших

### **Баримт нотолгоо, үнэлгээ:**

Дээрх зөвлөмж, шаардалгын дагуу дараах сайжруулалтыг хийж ажилласан нь дараах баримтуудаар нотлогдож байна. Үүнд:

1. СИС-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 10 сарын 22-ны А/78 тоот тушаалаар “Чанарын дотоод баталгаажуулалтын алба” байгуулагдан “Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, хүнлэг, соёлтой, насан туршдаа суралцах чадвар, мэдлэг бүхий иргэний бэлтгэхэд хамтын үнэ цэнийг дээшлүүлэхэд чиглэсэн чанарын бодлогыг тогтмол тасралтгүй сайжруулан ажиллах” гэсэн зорилго тавин ажиллаж байна.
2. СИС-ийн Чанарын дотоод баталгаажуулалтын албаны журам
3. Чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө
4. Чанарын дотоод баталгаажуулалтын албаны гарын авлагыг боловсруулсан байна.
5. Чанарын дотоод баталгаажуулалтын алба нь улирал тус бүрд суралцагчдын сурлагын ахиц дэвшил, хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа хийж, SWOT шинжилгээ хийн сайжруулах зөвлөмж өгч ажиллаж байна.
6. СИС нь 2022.01.31-нд МУ-ын дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагуудыг хангах системийн шийдлүүдийг TUS DX Core үйлчилгээгээр дамжуулан суурилуулах, төрөлжүүлэх зорилгоор БМИҮЗ, Тус Солюшн ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

**Шалгуурын хангасан байдал:** Бүрэн хангасан

## ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

- ✓ ДБМИК-ийн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 06 дугаар тогтоолоор уг хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр өгсөн 7 бүлэг зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шаардлагыг хангалттай гүйцэтгэлтэйгээр биелүүлсэн байна гэж дүгнэж байна.

Шалгуур		Бүрэн хангасан 2	Хэсэгчлэн хангасан 1	Хангаа гүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			<b>Бүрэн хангасан</b>
2	Сургалтын үйл ажиллагаа	3			<b>Бүрэн хангасан</b>
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			<b>Бүрэн хангасан</b>
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			<b>Бүрэн хангасан</b>
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	4			<b>Бүрэн хангасан</b>
6	Багшийн үйл ажиллагаа	2			<b>Бүрэн хангасан</b>
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	3			<b>Бүрэн хангасан</b>
	Нийт	26			
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

## Нэгдсэн зөвлөмж

Сургуулийн нэр	Сити их сургууль
Хөтөлбөрийн нэр	Жүжиглэх урлаг
Хөтөлбөрийн индекс	021510
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн оролцогч талуудын судалгааг тогтмолжуулж, чухал санал зөвлөмжийг хөтөлбөрт тусгаж, баталгаажуулан, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулалтыг хийж хэвших;</li> <li>- Хөтөлбөрийн зорилго, зорилтод хүрэх стратеги төлөвлөлтийг хийж, түүнийг үнэлэх арга, хэмжих нэгжийг тодорхой болгон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн хичээл нэг бүрийн суралцахуйн үр дүнг хичээлийн явцад болон төгсгөлд хэрхэн үнэлэх арга зүйн зөвлөмж бүхий гарын авлага боловсруулж, хөтөлбөрийн багш нарт хүртээл болгох;</li> <li>- Цаашид багш нарыг сурган, заах арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, тасралтгүй хөгжүүлэх зорилго бүхий багшийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх;</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>- Суралцагчийн хувь хүний ур чадварыг ялангуяа жүжигчний онолын мэдлэг, судалгааны ажил бичих ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай;</li> <li>- Оюутны байрны квот, хангамж хангалтгүй байгаа тул цаашид сайжруулах;</li> <li>- Оюутнуудын бие даасан сургуулилтын цаг, нөөц бололцоо гаргах тал дээр онцгой анхаарах шаардлагатай;</li> <li>- Мэргэжлийн багш нар гадаад хэл дээрх мэргэжлийн ном сурах бичгийг Монгол хэлрүү орчуулж, сургалтад ашиглах талд сургуулийн зүгээс бодлогоор дэмжих;</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулж буй дүрэм, журмын хэрэгжилтэд үнэлгээ, мониторингийг тогтмол хийж байх;</li> <li>- Санамж бичгийн түвшинд байгаа хамтын ажиллагааны баримт бичгүүдээ гэрээний түвшинд хөгжүүлж баталгаажуулах;</li> <li>- Хөтөлбөрийн төсвийн зарцуулалтын тайланг ил тод мэдээлэх механизмыг бүрдүүлэх;</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг элсэгчдэд тавих тусгай шаардлага, шалгууртаа тусгах;</li> <li>- Шилжилт хөдөлгөөний шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийх;</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөцийн бодлогыг СИС-ийн мастер төлөвлөгөөндөө дэлгэрэнгүй тусган, уг бодлогын хүрээнд дадлага, туршлагатай ахмад багш нарт залуу багш нарыг дагалдуулах замаар багш нарын залгамж халааг бэлтгэх шаардлагатай;</li> <li>- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг тодорхой болгох;</li> <li>- Багшийн урамшууллын бодлогыг боловсруулж, санхүүгийн төсөвт тусгах;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нарын бүтээлийг олон улсын хөндлөнгийн хянан магадлагаа бүхий сэтгүүлүүдэд хэвлүүлэх, гадаад хэлэнд хөрвүүлэхэд анхаарах;</li> <li>- Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоог нэмэгдүүлэх;</li> <li>- Ажлын үнэлгээтэй уялдуулан цалин хөлсийг нэмэгдүүлэхэд анхаарах;</li> </ul>
<p>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын чанарын баталгаажилтын журмын хэрэгжилтэд үнэлгээ, мониторинг хийх;</li> <li>- Сэтгэл ханамжийн судалгаа гүйцэтгэх цогц баримт бичиг боловсруулан мөрдөх;</li> <li>- Хөтөлбөрөө “хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үндэсний болон олон улсын шалгуур шаардлага”-д нийцүүлэн ахиц дэвшлээ тогтмол үнэлж хэвших;</li> </ul>

Шинжээч ..... Б.Отгонтөгс

2023 оны 1 дугаар сарын 28



Сургуулиас ирсэн албан бичиг:



## СИТИ ИХ СУРГУУЛЬ

Монгол Улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Денверийн гудамж-34  
Утас: 8908-8833  
Вэб: www.citi.edu.mn, И-мэйл: info@citi.edu.mn

2023.02.06 № 01/81

### БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

*Албан бичиг хүргүүлэх тухай:*

Жүжиглэх урлаг /D021505/ бакалаврын хөтөлбөрийн ахиц дэвшлийн үнэлгээний тайланд өгсөн шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Цаашид зөвлөмж, шаардлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллана.

ЕРӨНХИЙЛӨГЧ  Ц.БАЙГАЛМАА

